



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 4/59

Хөхөө

Шинжилгээнд хамруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/98 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/305 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын бруцеллёз өвчинтэй тэмцэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд азарганаас бусад хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний тандалт, шинжилгээг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж, шинжилгээнд шаардлагатай хүн хүч гаргаж хугацаанд нь түргэн шуурхай стандартын дагуу ажиллахыг Багийн Засаг дарга нар, сумын Мал эмнэлгийн тасагт тус тус даалгасугай.

2. Мал эрүүлжүүлэх, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалтын арга хэмжээнд зарцуулагдах бензин шатахууны зардал 191,800(нэг зуун ерэн нэгэн мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Нягтлан бодогч (Д.Баяржаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох тайлан мэдээг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Өлзийсайхан), Тархвар зүйч (Л.Бумбаяр) нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ